

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/246/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Төлбөрийн акт.....	11
3.2 Албан шаардлага	11
3.3 Зөвлөмж.....	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	13
4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	13
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/214
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА С.ОРХОН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Тус хэлтэс нь тайлант хугацаанд Засгийн газрын 2023 оны "Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар, "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 239 дүгээр тогтоол болон Нийгмийн даатгалын Ерөнхий газрын 2023 оны 01/1297 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэлтсийн даргын "Тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах тухай" 2023 оны А/10 дугаар тушаал баталж 17208 тэтгэвэр авагчийн тэтгэврийг шуурхай өөрчлөн тогтоож, нэмэгдлийг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс олгож ажилласан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/169 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д "Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын

G/Архив/Албан бичиг 2024/ А4

0190-7500

үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэнэ.” заалтыг үндэслэн Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийг Төв аймгийн Нийгмийн даатгалын газар гэж өөрчлөн 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг 96,1 хувиар биелүүлсэн бөгөөд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг өмнөх оноос 1,120,751.2 мянган төгрөгөөр буюу 57,4 хувиар өсгөсөн нь шимтгэлийн авлагыг барагдуулах замаар орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Arkhib/Alban bichig 2024/ A4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,746,968,373.23	20,382,735,696.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,758,338,219.12	15,337,928,129.69
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,758,338,219.12	15,337,928,129.69
31210	Төгрөг	10,758,338,219.12	15,337,928,129.69
31211	Төрийн сангийн харилцах	0	577,478,915.37
31213	Арилжааны банк дахь харилцах	10,758,338,219.12	14,760,449,214.32
33	АВЛАГА	5,973,189,880.44	5,022,589,671.82
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,003,665,515.02	3,112,450,464.39
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,529,369,062.02	1,431,179,494.48
33500	Бусад авлага	440,155,303.40	478,959,712.95
33510	Байгууллагаас авах авлага	439,810,475.40	478,959,712.95
33520	Хувь хүмүүсээс авах авлага	344,828.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	15,440,273.67	22,217,894.70
35400	Хангамжийн материал	15,440,273.67	22,217,894.70
35410	Бичиг хэргийн материал	745,850.01	4,666,700.01
35420	Аж ахуйн материал	10,206,872.68	13,157,672.68
35430	Сэлбэг хэрэгсэл	2,749,230.00	2,416,100.00
35450	Барилгын засварын материал	104,120.00	0
35470	Бусад хангамжийн материал	1,634,200.98	1,977,422.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	628,177,323.32	615,195,614.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	628,177,323.32	615,195,614.92
39200	Биет хөрөнгө	603,976,871.84	591,795,313.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	529,621,659.99	529,621,659.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-44,725,517.00	-55,741,715.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,300,000.00	12,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,441,922.18	-4,491,922.14
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	218,433,358.60	226,221,383.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-120,928,170.84	-124,679,337.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,775,886.00	45,020,079.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,058,422.73	-36,454,833.83
39300	Биет бус хөрөнгө	24,200,451.48	23,400,300.96
39301	Програм хангамж	3,200,602.00	3,200,602.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-800,150.52	-1,600,301.04
39303	Бусад биет бус хөрөнгө	21,800,000.00	21,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,375,145,696.55	20,997,931,311.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	738,552,664.95	1,229,277,771.11
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	738,552,664.95	1,229,277,771.11
41300	Өглөг	360,824,381.34	463,703,777.47
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	344,828.00	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	360,479,553.34	463,703,777.47
41400	Урьдчилж орсон орлого	377,728,283.61	765,573,993.64
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	377,728,283.61	765,573,993.64
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,636,593,031.60	19,768,653,540.02
51	Засгийн газрын хувь оролцоо	16,636,593,031.60	19,768,653,540.02
51100	Засгийн газрын оруулсан капитал	339,724,535.61	339,724,535.61
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	339,724,535.61	339,724,535.61
51200	Хуримтлагдсан үр дүн	16,130,928,464.60	19,262,988,973.02
51210	Өмнөх үеийн үр дүн	17,333,473,498.55	16,132,202,853.59
51220	Тайлант үеийн үр дүн	-1,202,545,033.95	3,130,786,119.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,940,031.39	165,940,031.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,375,145,696.55	20,997,931,311.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	182,908,840,611.26	140,861,785,104.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	40,121,786,389.95	51,884,910,766.97
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	40,121,786,389.95	51,884,910,766.97
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,721,482,724.68	35,748,029,669.06
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,894,269,844.03	3,738,729,394.95
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,125,759,956.69	2,725,095,280.60
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	541,374,276.13	706,434,254.34
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,838,899,588.42	8,966,622,168.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	302,107,787.18	146,899,975.29
120	Нийтлэг татварын бус орлого	302,107,787.18	146,899,975.29
120002	Хүүгийн орлого	3,917,473.13	76,884,325.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,162,625.05	43,662,949.75
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,026,615.05	43,662,949.75
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,010.00	0
120009	Бусад орлого	230,027,689.00	20,957,571.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	5,395,129.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,484,946,434.13	88,829,974,362.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	12,883,371,711.00	14,850,574,119.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,883,371,711.00	14,850,574,119.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	72,327,972.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	15,994,051.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	56,333,921.00
1330	Төсвийн захирагчдаас	128,696,372,423.13	72,312,035,470.64
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	128,696,372,423.13	72,312,035,470.64
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	904,202,300.00	1,595,036,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	895,793,200.00	1,595,036,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,409,100.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	184,111,385,645.21	137,730,998,985.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	184,111,385,645.21	137,730,998,985.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	897,964,644.09	1,452,197,143.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,648,625.06	1,135,121,507.38
210101	Үндсэн цалин	505,183,883.80	662,659,097.47
210102	Нэмэгдэл	109,079,104.19	329,459,357.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,845,981.45	38,213,943.95
210104	Урамшуулал	42,539,655.62	104,789,108.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,547,073.15	143,902,972.23
210201	Тэтгэврийн даатгал	60,402,985.15	99,974,295.71
210202	Тэтгэмжийн даатгал	7,064,346.33	11,696,946.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,497,077.23	9,203,717.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,306,635.71	2,069,239.94
210205	Эрүүл мэндийн даатгал	13,276,028.73	20,958,772.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,580,433.00	54,693,793.83
210301	Гэрэл, цахилгаан	3,650,194.00	4,532,827.22
210302	Түлш, халаалт	40,765,800.00	47,390,022.61
210303	Цэвэр, бохир ус	2,164,439.00	2,770,944.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,434,014.99	30,284,404.97
210401	Бичиг хэрэг	4,078,250.00	6,217,300.00
210402	Тээвэр, шатахуун	16,700,200.00	2,570,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,239,900.00	6,433,736.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	228,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,187,664.99	14,503,950.00
210408	Бараа материал ахталсны зардал	0	79,218.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,141,750.00	17,155,120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	295,870.00	1,061,030.00
210604	Урсгал засвар	845,880.00	16,094,090.00
2107	Томиллолт, зочны зардал	2,650,000.00	7,676,360.00
210702	Дотоод албан томиллолт	2,650,000.00	7,676,360.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,390,689.00	20,951,677.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,105,800.00	8,158,990.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,785,600.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,900.00	66,812.00
210807	Газрын төлбөр	65,325.00	65,325.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,059,970.00	9,362,790.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,755,094.00	1,297,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,572,058.89	42,411,308.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	514,800.00	1,827,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,057,258.89	40,083,608.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	183,213,421,001.12	136,278,801,841.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,866,350,864.00	121,202,519,451.18
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	102,832,139,627.00	121,154,804,101.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,739,037.00	8,095,950.18
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,472,200.00	39,619,400.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	80,347,070,137.12	15,076,282,390.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,347,070,137.12	15,076,282,390.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,202,545,033.95	3,130,786,119.43
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,202,545,033.95	3,130,786,119.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	183,579,881,892.91	142,460,328,391.84
11	ТАТВАРЫН ОРЛОГО	39,491,961,008.74	50,884,927,777.27
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	39,491,961,008.74	50,884,927,777.27
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,285,023,747.32	35,087,367,260.05
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,845,399,949.35	3,665,006,820.16
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,088,676,549.53	2,668,399,786.36
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	532,760,639.79	690,142,452.65
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,740,100,122.75	8,774,011,458.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	410,096,137.04	242,224,041.87
120	Нийтлэг татварын бус орлого	410,096,137.04	242,224,041.87
120002	Хүүгийн орлого	3,917,473.13	52,429,882.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	406,178,663.91	189,794,159.03
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	406,042,653.91	189,794,159.03
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,010.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,677,824,747.13	91,333,176,572.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,158,109,800.00	17,362,862,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,158,109,800.00	17,362,862,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	72,327,972.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	0
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	15,994,051.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	56,333,921.00
1330	Төсвийн захирагчдаас	128,614,512,647.13	72,302,949,700.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	128,614,512,647.13	72,302,949,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	904,202,300.00	1,595,036,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	895,793,200.00	1,595,036,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,409,100.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	184,444,455,405.98	137,864,738,481.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	184,444,455,405.98	137,864,738,481.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	873,863,784.53	1,413,541,976.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,811,720.47	1,135,121,507.38
210101	Үндсэн цалин	505,188,494.03	662,659,097.47
210102	Нэмэгдэл	109,079,104.19	329,459,357.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,845,981.45	38,213,943.95
210104	Урамшуулал	42,698,140.80	104,789,108.80

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,009,366.06	143,902,972.23
210201	Тэтгэврийн даатгал	62,152,899.60	99,974,295.71
210202	Тэтгэмжийн даатгал	7,064,346.78	11,696,946.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,575,463.69	9,203,717.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,306,635.71	2,069,239.94
210205	Эрүүл мэндийн даатгал	13,910,020.28	20,958,772.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,580,433.00	54,429,449.83
210301	Гэрэл, цахилгаан	3,650,194.00	4,532,827.22
210302	Түлш, халаалт	40,765,800.00	47,390,022.61
210303	Цэвэр, бохир ус	2,164,439.00	2,506,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,566,270.00	33,712,200.00
210401	Бичиг хэрэг	4,085,700.00	8,479,350.00
210402	Тээвэр, шатахуун	16,700,200.00	2,570,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,239,900.00	4,979,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	228,000.00	228,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,312,470.00	17,454,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,095,600.00	16,717,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,145,600.00	727,900.00
210604	Урсгал засвар	950,000.00	15,989,970.00
2107	Томилолт, зочны зардал	2,650,000.00	7,676,360.00
210702	Дотоод албан томилолт	2,650,000.00	7,676,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,635,595.00	20,153,917.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,105,800.00	8,658,990.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,785,600.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,900.00	66,812.00
210807	Газрын төлбөр	65,325.00	65,325.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,059,970.00	9,362,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	514,800.00	1,827,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	514,800.00	1,827,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	183,570,591,621.45	136,451,196,504.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,223,521,484.33	121,374,914,114.49
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	102,849,038,158.00	121,102,132,495.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,739,037.00	8,095,950.18
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	340,272,089.33	225,066,269.31
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,472,200.00	39,619,400.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	80,347,070,137.12	15,076,282,390.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,347,070,137.12	15,076,282,390.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-864,573,513.07	4,595,589,910.57
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	16,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	16,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	16,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	16,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-16,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-864,573,513.07	4,579,589,910.57
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,622,911,732.19	10,758,338,219.12
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,758,338,219.12	15,337,928,129.69

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	17,325,617,684.54	17,831,282,251.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	7,855,814.00	7,855,814.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	17,333,473,498.55	17,839,138,065.55
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт буурал	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-1,202,545,033.95	-1,202,545,033.95
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	16,130,928,464.60	16,636,593,031.60
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	16,130,928,464.60	16,636,593,031.60
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,274,388.99	1,274,388.99
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	16,132,202,853.59	16,637,867,420.59
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	3,130,786,119.43	3,130,786,119.43
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,724,535.61	165,940,031.39	19,262,988,973.02	19,768,653,540.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,921,627,200.00	122,507,061,848.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,921,627,200.00	122,507,061,848.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,557,351,900.00	1,357,214,003.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,243,776,200.00	1,084,995,983.95
210101	Үндсэн цалин	708,976,600.00	662,659,097.47
210102	Нэмэгдэл	358,840,900.00	279,333,833.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,120,200.00	38,213,943.95
210104	Урамшуулал	123,838,500.00	104,789,108.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,472,100.00	137,700,522.96
210201	Тэтгэврийн даатгал	105,721,100.00	95,713,626.21
210202	Тэтгэмжийн даатгал	12,437,800.00	11,195,691.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,950,200.00	8,802,713.07
210204	Ажилгүйдлийн даатгал	2,487,500.00	1,974,738.09
210205	Эрүүл мэндийн даатгал	24,875,500.00	20,013,754.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,906,700.00	54,429,449.83
210301	Гэрэл, цахилгаан	5,128,100.00	4,532,827.22
210302	Түлш, халаалт	48,272,000.00	47,390,022.61
210303	Цэвэр, бохир ус	2,506,600.00	2,506,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,768,800.00	33,712,200.00
210401	Бичиг хэрэг	8,485,700.00	8,479,350.00
210402	Тээвэр, шатахуун	16,700,200.00	2,570,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,979,900.00	4,979,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	228,000.00	228,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,375,000.00	17,454,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,815,400.00	16,717,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,415,400.00	727,900.00
2107	Томилолт, зочны зардал	11,637,100.00	7,676,360.00
210702	Дотоод албан томилолт	11,637,100.00	7,676,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,075,600.00	20,153,917.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,029,100.00	8,658,990.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	66,812.00
210807	Газрын төлбөр	100,000.00	65,325.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,296,500.00	9,362,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	1,827,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,827,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,364,275,300.00	121,149,847,845.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,364,275,300.00	121,149,847,845.18
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	124,316,388,900.00	121,102,132,495.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,267,000.00	8,095,950.18
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,619,400.00	39,619,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,921,627,200.00	59,572,623,842.95
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,362,862,100.00	17,362,862,100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	17,362,862,100.00	17,362,862,100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
320001	Орон нутгийн төсвөөс	0	0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,558,765,100.00	42,161,567,646.85
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	108,558,765,100.00	42,161,567,646.85
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	48,194,096.10
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	48,194,096.10
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	11,622,911,732.19	10,758,338,219.12
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	10,758,338,219.12	15,337,928,129.69
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	54	50
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	48	44
620003	Үйлчлэх ажилтан	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,000.00	72,327,972.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000.00	56,327,972.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	56,327,972.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	50,125,523.43
210102	Нэмэгдэл	0.0	50,125,523.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	6,202,449.27
210201	Тэтгэврийн даатгал	0.0	4,260,669.50
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	501,255.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	401,004.19
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	94,501.85
210205	Эрүүл мэндийн даатгал	0.0	945,018.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	16,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	16,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	16,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,000,000.00	72,327,972.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	72,327,972.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		15,994,051.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		56,333,921.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нэмэлт санхүүжилтийн тайланг өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй 1,000.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 54 дүгээр зүйлийн 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” журмын 2.1.8-д “Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад төсвийн байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэхүйц” байх зарчим болон санхүүгийн тайлангийн “толилуулга”, “иж бүрэн байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

Аудитаар нийт 1,121,665.6 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрсэнд, 502.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,120,751.2 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүргүүлж (нэг зөрчил нь нийцлийн аудитын асуудал тул энэ тайлангийн 4.4.2-д шийдвэрлэлтийг тайлагналаа), зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 412.4 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө. Үүнд:

331 Төлбөрийн акт

НДЕГ, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс сумдад томилолтоор ажилласан 12 албан хаагчид албан томилолтоор ажиллах үеийн хоолны нөхөх төлбөр, албан хаагчийн хоолны зардлын нөхөх төлбөрийг давхардуулан тооцож 122.0 мянган төгрөг илүү олгосон, унааны зардалд анхан шатны баримтгүй 380.0 мянган төгрөгийг олгож нийт 502.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

3.2 Албан шаардлага

1. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өмнөх тайлант оноос 1,120,751.2 мянган төгрөгөөр буюу 57,4 хувиар өссөн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ”, НДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны 06 дугаар тогтоолын 4-д “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, шимтгэлийн авлагыг барагдуулах замаар орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх...” заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “тасалбар болголт”, “толилуулга”, “ангилал”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

2. Нийгмийн даатгалын сангийн шилэн дансанд байршуулах мэдээллүүдийг тайлант оны 1, 2, 3 дугаар улиралд байршуулаагүй, Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны

батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар шивж оруулаагүй, PDF форматаар байршуулаагүй, орон тооны мэдээллийг 11 удаа байршуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулаагүй, шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 5 дугаар зүйлийн 5.1.3-д "тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх", 8 дугаар зүйлийн 8.2-д "Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" гэж заасантай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "оршин байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-д " аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд "...нийгмийн даатгалын санд 44,649,132.3 мянган төгрөгийн шимтгэлийн орлогоос 45,497,465.8 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 101,9 хувьтай гэх боловч санхүүгийн тайлангийн гүйцэтгэлээр Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөний биелэлт 96,1 хувьтай, төлөвлөгөөг биелүүлээгүй зөрүүтэй тайлагнасан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д “нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах”, НДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны 06 дугаар тогтоолын 4-д “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, шимтгэлийн авлагыг барагдуулах замаар орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх...” заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

1.2. Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг төрөл тус бүрээр жигд ханган биелүүлэх, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргаж тайлагнах

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Албан томилолтын зардлаас тээвэр шатахууны зардалд 412.4 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, шууд зардалд бичсэн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүжүүлэх зардлын зүйл ангийг зөв тодорхойлох

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтын дагуу ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх оны үзүүлэлттэй зэрэгцүүлсэн хэлбэрээр тайлагнах	1	1,000.0	1	1,000.0			1	1,000.0				
Дүн	1	1,000.0	1	1,000.0			1	1,000.0	0	0	0	0

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Албан томилолтоор ажиллах үеийн хоолны нөхөх төлбөрт нийт 502.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил байна.	1	502.0	1	502.0							
Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өмнөх оноос 1,120,751.2 мянган төгрөгөөр буюу 57,4 хувиар өссөн зөрчил байна.	1	1,120,751.2			1	1,120,751.2					
Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөний биелэлт 96,1 хувьтай, төлөвлөгөөг биелүүлээгүй зөрчил байна.	1	0					1	0			
Албан томилолтын зардлаас тээвэр шатахууны зардалд гүйлгэн зарцуулж, шууд зардалд бичсэн зөрчил байна.	1	412.4					1	412.4			
Дүн	4	1,121,665.6	1	502.0	1	1,120,751.2	2	412.4			

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны байршуулах мэдээллүүдийг 1, 2, 3 дугаар улиралд байршуулаагүй, Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг оруулаагүй, орон тооны мэдээллийг 11 удаа байршуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулаагүй, шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил байна.	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0			1	0		